



Ирвэс Хамгаалах Сангийн Ирвэс Энтерпрайз хөтөлбөр

**УВС АЙМГИЙН БӨХМӨРӨН СУМЫН ШАРХАРГАЙ, ЦАГААН ОВОО, ЦАХИР
НӨХӨРЛӨЛД ХУРГАНЫ НООСНЫ АНХАН ШАТНЫ БОЛОВСРУУЛАЛТ,
БОЛОВСРУУЛСАН НООСООР ЭСГИЙ, ЭСГИЙ БҮТЭЭГДЭХҮҮН ХИЙХ, САРЛАГИЙН
ХӨӨВРӨӨР УТАС ЭЭРЭХ ДАВТАН СУРГАЛТ**



Тайланг бичсэн: Д.Өнөрзул (“Ирвэс Хамгаалах Сан”-ийн
бүтээгдэхүүний загвар хариуцсан ажилтан)

**Улаанбаатар хот
2009 он**

Сургагч багшийн овог, нэр :	Д.Өнөрзул
Гэрээний дугаар :	
Сургалтын сэдэв :	Хурганы ноосны анхан шатны боловсруулалт, боловсруулсан ноосоор эсгий, эсгий бүтээгдэхүүн хийх, сарлагийн хөөврөөр утас ээрэх давтан сургалт
Ажилласан хугацаа :	2009/7/31-2009/8/5
Сургалт авсан нөхөрлөлийн нэр :	Шархаргай, Цахир, Цагаан Овоо нөхөрлөлүүд
Сургалт явагдсан газар :	Увс аймаг Бөхмөрөн сум Цагаан Түнгийн застав

1. Урьдчилсан мэдээлэл (орон нутагт хийсэн аялал, оролцогчдын талаарх мэдээлэл г.м.)

<p>Увс аймгийн Бөхмөрөн сум Шархаргай, Цахир, Цагаан Овоо нөхөрлөлүүдэд хурганы ноос, сарлагийн хөөврийн анхан шатны боловсруулалт хийх, боловсруулсан ноосоор хавтгай амьтны дүрс болон утас ээрэх давтан сургалтыг явууллаа. Энэ сургалтанд нөхөрлөлүүдийг төлөөлж 10 гишүүн оролцсон. Эдгээр нөхөрлөлийн гишүүд нь 2008 оны 5 сард сарлагийн хөөврийн анхан шатны боловсруулалт хийх, боловсруулсан хөөврөөр сүлжмэлийн зориулалттай ээрмэл утас ээрэх сургалтыг авч байсан. Энэ удаагийн сургалтаар өмнө нь явуулсан сургалтыг бататгаж утас ээрэх давтан сургалт мөн хурганы ноос боловсруулан эсгий, эсгий бүтээгдэхүүн хийх дунд шатны сургалтыг явууллаа. АНУ-ын зах зээлд борлуулалт сайтай, захиалга нэмэгдэх хандлагатай байгаа бүтээгдэхүүнийг сонгон авч зааж сургалаа.</p> <p>Сургалтанд оролцогчдын нэр:</p> <p>1.Отгонцэнхэр 2.Нямгэрэл 3.Жигүүр 4.Уртнасан 5.Цэвэлмаа 6.Цогзолмаа 7.Оюунгэрэл 8.Тодноо 9.Мандах. 10.Өлзидэлгэр.</p> <p>Тайлбар: Өмнө нь явуулсан сургалтаас хойш нөхөрлөлийн гишүүд тоног төхөөрөмжгүй байсан учраас энэ хугацаанд дахин утас ээрэх дадлага хийгээгүй бөгөөд зарим нэг зүйлийг мартсан байлаа. Иймээс 5 өдрийн сургалтын эхний хоёр өдөр нь ээрмэлийн давтан сургалт явуулж өмнө нь сурсан зүйлийг сэргээж ээрсэн утсыг шалган хүн нэг бүрт зөвлөгөө өгсөн.</p>

2. Сургалтын явц

Сургалтын хөтөлбөрийн дагуу сургалт явагдсан.

2009.07.31 Сарлагийн хөөврөөр утас ээрэх дадлага

Нөхөрлөлүүд өмнө нь сургалт авч байсан учраас сарлагийн хөөврөө урьдчилан бэлтгэсэн байв. Сургалтын эхний өдөр ээрэх дадлага машин дээр хийцгээсэн.

2009.08.01 Сарлагийн хөөврөөр утас ээрэх дадлага.



Ээрмэлийн давтан сургалтаар хүн тус бүр стандартад нийцэхүйц 1 ширхэг утас ээрсэн. Утсаа ээрч дууссаны дараа ноосон бүтээгдэхүүн угаах горимын дагуу утсаа угааж хатаав. Давтан сургалт дуусмагц дунд шатны сургалтанд зориулж хурганы ноос цэвэрлэж бэлтгэсэн. Аливаа түүхий эдэд анхан шатны

боловсруулалт хийхэд цаг ихээхэн шаарддаг. Эсгий, эсгий бүтээгдэхүүн хийхэд зориулж хүн тус бүр 200гр хурганы ноос цэвэрлэж, угааж бэлтгэсэн.

2009.08.02 Цэвэрлэж бэлтгэсэн ноосоор хавтгай эсгий хийх

Хавтгай эсгий хийх. Анхан шатны боловсруулалт хийгдсэн ноосыг самнагч машинаар самнахын өмнө заавал гараар сэмлэх шаардлагатай. Гараар сэмлэлгүй самнагч машинд оруулсан тохиолдолд самнагч машины шүд маш хурдан эвдрэх аюултай байдагийг анхааруулсан. Эсгийг жигд нимгэн хийхийн тулд ноосыг сайтар самнаж өгөх нь чухал байдаг. Сургалтанд оролцсон хүмүүст самнагч машины горимыг танилцуулан дадлага хийлгэж сургалтын хэрэгцээний ноосыг хүн тус бүрээр самнуулсан. Самнах ажиллагаа явагдсаны дараа хавтгай эсгий хийхэд шаардагдах материал тоног төхөөрөмж болон эсгий



/ 3-р зураг /



/ 4-р зураг /



/2-р

зураг/

хийх технологи ажиллагааг танилцуулж дадлага хийцгээв. Хавтгай эсгий хийхэд дараах анхаарах зүйлүүд байдаг. Үүнд:

- самнасан ноосыг давхарлахдаа цувималын ширхэгийг ямарч тохиолдолд зөрүүлж тавих шаардлагатай.

- эсгий хийх явцдаа бүтээгдэхүүний загварын дагуу хээ зураг болон толбо зэргийг гаргаж өгөх.

- эсгийг хийж гүйцмэгц цэвэр усанд сайтар угаах шаардлагатай. /цэвэр усанд сайтар угаагүй дохиолдолд эсгий хатахдаа шарладаг/

Битүү аргаар эсгий бойтог, оймс хийх. Битүү аргаар эсгий хийх нь хавтгай эсгий



хийхээс ихээхэн ялгаатай техник юм. Энэ аргаар эсгий хийсэн тохиолдолд бүтээгдэхүүний гүйцэтгэл илүү хялбар болж өгдөг. Энэ сэдвийн хүрээнд хүн тус бүр 2 хос оймс сарлагийн хөөвөр, хурганы ноосоор хийсэн.

2009.08.03 Бэлэн болсон эсгийгээр загварын дагуу бүтээгдэхүүн хийх.

Ирвэсний дүрс бүхий тоглоом. Энэ нь ирвэсний дүрсийг хийхэд хялбар хэлбэрт оруулсан шинэ жилийн чимэглэл бөгөөд АНУ-д борлуулалт сайтай байгаа бүтээгдэхүүний нэг юм.

Өөрсдийн хийсэн эсгийн дээр дүрсээ харандаагаар буулгаж хоёр арыг хавсран товчны нүх оёх оёдлоор оёж нүд, чих, ам зэргийг хатгаж гаргана. Дүрсээ тойруулж оёх



явцдаа бүх хэсэгт сул ноос бага хэмжээрээр чихэж өгөх хэрэгтэй.

Сургалтанд оролцсон хүн тус бүр 2 ирвэс оёсон.

2009.08.04 Бүтээгдэхүүний гүйцэтгэл

Сургалтанд оролцогсад сургалтын сэдвийн хүрээнд тус бүр 2 ширхэг хавтгай ирвэс, 2 хос эсгий оймс, 2 ширхэг утас зэрэг бүтээгдэхүүн хийж сурцгаасан. Бүтээгдэхүүний гүйцэтгэл бүрэн дүүрэн явагдсан бөгөөд бүтээгдэхүүний гүйцэтгэлийг нэг бүрчлэн шалгаж хүн бүрт зөвлөгөө өгсөн.

Тайлбар: Сургалтын хүрээнд заагдсан сэдвээр ганц дээрх бүтээгдэхүүнийг хийх бус эсгий хийх аргуудыг ашиглан өөр олон нэр төрлийн бүтээгдэхүүн хийх жишээ нь цүнх, гэрийхг шаахай, малгай, бээлий зэргийг хийж амьдрал ахуйдаа ашиглах бүрэн боломжтой юм.

3. Сургалтанд оролцогчсодтой хамтран ажилласан байдал (саад бэрхшээл, боломж г.м.)

Суралцагсад багшийн удирдлаган доор сургалт дадлагаар явагдсан. Сургалт сонирхолтой байсан учраас саад бэрхшээл харьцангуй бага байсан. 5 хоногийн сургалт анхан шатны сургалттайгаа цуг явагдсан учраас эсгий бүтээгдэхүүн хийх дадал чадвар олгох хугацаа маш богино байсан хэдий ч суралцагсад цаашдаа чадвараа улам сайжруулна гэдэгт итгэж байна.Эдгээр сургалт авсан нөхөрлөлүүд багаж тоног төхөөрөмжөө хурдан хугацаанд авах бүрэн боломжтой юм.Сургалтанд оролцсон нөхөрлөлийн гишүүд сургалт явагдах газраас нилээд зайтай байсан нь сургалт цагтаа эхлэхэд хүндрэл учирч байсан хэдий ч сургалт явагдсан газар 5 хоног байрлан сургалтанд оролцсон нь сургалтын ирц хийгээд чанарт сайнаар нөлөөлсөн.

Тайлбар:

4. Сургалтанд оролцогсдод өгсөн зөвлөмж

Ноосны анхан шатны боловсруулалт хэрхэн хийгдэх нь бүтээгдэхүүний өнгө загварт шууд нөлөөлдгийг сайтар хэлж зөвлөсөн. Сургалтын дараа хийсэн бүтээгдэхүүнд нь хүн нэг бүрт эсгийний нимгэн зузааныг хэрхэн тохируулах, хэлбэр дүрс, өнгө зэргийг алдагдуулалгүй хэрхэн гүйцэтгэл хийх тал дээр зөвлөгөө өгөхөөс гадна гарын авлагаар хангасан. Бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн шаардлага сонирхолд нийцэхээр

хийхийн тулд байнгын дадлага хэрэгтэй юм.

Тайлбар:

5. Дүгнэлт

1.Орон нутагт үйл ажиллагаа явуулахад тохиолддог хүндрэл бэрхшээл багагүй байдагч Цахир, Цагаан Овоо, Шархаргай нөхөрлөлийн сургалтанд оролцсон гишүүдийн идэвхи, үйл ажиллагаа сайн байсан нь сургалтын чанарт сайнаар нөлөөлсөн.Тус нөхөрлөлүүдийг төлөөлж сургалтанд оролцсон нөхөрлөлийн гишүүд цаашид өөрсдийн бусад гишүүдээ сургах дадал чадварыг сайн эзэмшсэн гэж үзэж байна.Энэ дундаас Оюунгэрэл, Жигүүр, Тодноо нарын нэрийг дурьдах нь зүйтэй юм.

2.Цаашид нөхөрлөлийг чадавхижуулах энэ төрлийн зөвлөгөө мэдээллээр хангах нь нэн шаардлагатай асуудал юм. Үүнийг Ирвэс Хамгаалах Сан төдийгүй Дэлхийн Байгаль Хамгаалах Сан анхаарч ажиллах нь зүйтэй юм.

3.Сургалтын чанар хийгээд явц хөтөлбөрийн дагуу сайн явагдсан гэж үзэж байна.

4. Цаашид эдгээр нөхөрлөлүүд Ирвэс Энтерпрайз хөтөлбөрт хамрагдаж чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлоход нь ИХС бүтээгдэхүүн захиалгах, худалдан авах бүртээ зөвлөгөө, нэмэлт сургалтыг өгч ажиллах болно.

5. Сургалтанд хамрагдсан малчид ИХС-ийн экспорлож байгаа 2 төрлийн бүтээгдэхүүн, өөрсдийн ахуй амьдралдаа хэрэглэх 1 бүтээгдэхүүнийг хийх дадлага чадвар эзэмшсэн болно.



Тайлбар: Хавтгай ирвэс, сарлагийн ээрсэн утас

Тайланг бичсэн/ИХС-ийн бүтээгдэхүүний загвар хариуцсан
ажилтан Д.Өнөрзул /

Хавсралтууд:

- Хавсралт 1. Сургалтын хөтөлбөр
- Хавсралт 2. Сургалтын гарын авлага
- Хавсралт 3. Сургалтын зураг

“Ирвэс Хамгаалах Сан”ТББ

Ирвэс Энтерпрайз хөтөлбөр

Ээрмэлийн давтан сургалт, хонины ноосны анхан шатны боловсруулалт, эсгий бүтээгдэхүүн хийх сургалтын хөтөлбөр

Сургалтын зорилго: Увс аймаг Бөхмөрөн сумын Цагаан Түнгийн заставын Ацт хар, Цагаан-овоо, Цахир, Шаргай зэрэг 4 нөхөрлөлийн малчдад ээрмэлийн давтан сургалт явуулах болон хонины ноосны анхан шатны боловсруулалт, эсгий бүтээгдэхүүн хийх анхан шатны мэдлэг олгоход энэхүү сургалтын зорилго оршино.

Сургалтын цагийн хуваарь

Хүснэгт 1

Өдөр	Хугацаа	Сургалтын агуулга
1 өдөр	09:00-13:00	Хурганы ноос болон сарлагийн хөөвөр цэвэрлэх анхан шатны боловсруулалт.
	13:00-14:00	Цайны завсарлага
	14:00-18:00	Хурганы ноос болон сарлагийн хөөвөр цэвэрлэх анхан шатны боловсруулалт.
2 өдөр	09:00-13:00	Цэвэрлэсэн ноосыг эсгий хийхэд бэлтгэх самнах, зулах.
	13:00-14:00	Цайны завсарлага
	14:00-18:00	Хавтгай болон цул эсгий хийх техниктэй танилцах, гүйцэтгэх, угааж хатаах.
3 өдөр	09:00-13:00	Бэлэн болсон эсгийгээр зааврын дагуу бүтээгдэхүүн хийх.
	13:00-14:00	Цайны завсарлага
	14:00-18:00	Бүтээгдэхүүний гүйцэтгэн боловсруулалт.
4 өдөр	09:00-13:00	Ээрмэлийн давтан сургалт.
	13:00-14:00	Цайны завсарлага
	14:00-18:00	Утас ээрэх дадлага.
5 өдөр	09:00-13:00	Утас ээрэх дадлага.
	13:00-14:00	Цайны завсарлага
	14:00-18:00	Нийтгэх ээрсэн утсыг ноосон бүтээгдэхүүн угаах горимын дагуу угааж хатаах

**Нийт 5 хоног буюу 40 цагийн хичээл үзнэ.
Суралцах хүний тоо 12.**

“Ирвэс Хамгаалах Сан”ТББ
хөтөлбөр

Ирвэс Энтерпрайз

**Ээрмэлийн давтан сургалт, хонины ноосны анхан шатны
боловсруулалт, эсгий бүтээгдэхүүн хийх сургалтанд хэрэглэгдэх тоног
төхөөрөмж, материал
(12 хүн)**

дд	Хэрэглэгдэх материал, тоног төхөөрөмж	Тоо ширхэг	Хаанаас
1	Хурганы ноос хүн тус бүр	300 гр	Сургалтанд оролцогсод
2	Сарлагийн хөөвөр хүн тус бүр	300 гр	Сургалтанд оролцогсод
3	Ээрэгч машин	4ш	ИХС, сургалтанд оролцогсод
4	Самнагч машин	1ш	ИХС
5	Саван	6ш	ИХС
6	Гялгар цаас	2м	ИХС
7	Тюль	2м	ИХС
8	Түмпэн	6ш	Сургалтанд оролцогсод
9	Угаалгын нунтаг	2ш	ИХС
10	Резинен бээлий	12ш	ИХС
11	Сургалтын гарын авлага	12ш	ИХС
12	Жин, метр	1ш	ИХС
13	Зүү	12ш	Сургалтанд оролцогсод
14	Хайч	4ш	Сургалтанд оролцогсод
15	Метр	2ш	ИХС
16	Алчуур	12ш	Сургалтанд оролцогсод
17	Сургалтын хоол хүнс		Сургалтанд оролцогсод

Хугацаа: - 2009.7.31-2009.8.4-ныг дуустал 5 хоног

/Үүнд: Ээрмэлийн давтан сургалт 2 өдөр, эсгий хийх гүнзгийрүүлсэн сургалт 3 өдөр/

Өглөө: 9.00 – 18.00 цаг хүртэл өдрийн 8 цаг

Үдийн цайны цаг: 13.00 – 14.00 цаг

Сургалтаар заагдах сэдэв:

1. Сарлаг самнаж хөөвөр бэлтгэх.
2. Сарлагийн хөөврийн анхан шатны боловсруулалт.
3. Боловсруулсан ноосоо самнах болон цувимал болгох.
4. Тоног төхөөрөмжийн бүтэц үйл ажиллагаатай танилцах, ажиллах дадлага хийх.
5. Утас ээрэх төрлүүд /энгийн нарийн ээрэлт/
6. Дан ээрэлт.
7. Давхар ээрэлт.
8. Ээрсэн утсаа стандартын дагуу ороох.

Сургалтын хөтөлбөр боловсруулсан :

“Ирвэс Хамгаалах Сангийн”
ТББ-ын Бүтээгдэхүүний загвар
хариуцсан ажилтан

..... /Д.Өнөрзул/

СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

Сарлагийн хөөврийн анхан шатны боловсруулалт

Сарлагийн тухай товчхон

Сарлагийн талаарх анхны тэмдэглэлийг XIII-р зууны үед Марко Поло анхлан гаргажээ.1879-1880 онд Х.М Прежевальский Түвдийн сарлагийн талаарх нилээд тодорхой мэдээллийг анх удаа хийжээ.Дэлхийн зах заалд ноолууран эдлэлийн эрэлт хэрэгцээ жил ирэх тусам өсөн нэмэгдэж, үүнийг даган үнэ ч өсч байна. Монгол улс ноолууран түүхий эдийн нөөцөөрөө дэлхийд зөвхөн БНХАУ-н дараа ордог.Ноос ноолуурыг ихэвчлэн хагас боловсруулсан хэлбэрээр экспортолдог хязгаарлагдмал бараа бүтээгдэхүүнтэй манай улсын хувьд дэлхийд ховорт тооцогддог пигментд ноос ноолуурыг Манай улс 500 мянга орчим сарлагтай бөгөөд сарлагийн тоогоор дэлхийд 2-р байранд орж жилдээ 300 гаруй тонн сарлагийн хөөврийг бэлтгэж байна.

Сарлагийн утас бэлтгэх арга зүй техник

Самнаж авах, ангилан ялгах: Сарлагийн хөөврийг самнаж авахдаа ямааны сам ашиглана. Бярууны их биений хэсгийн хөөврийг самнаж авна. Самнах явцдаа өнгө болон урт богино, хялгасаар нь ялгаж самнавал дараа нь боловсруулалт хийхэд хялбар байх болно. Өнгөөр нь ялгасан ноосныхоо том хаг, хогийг нь сэгсэрч унагаана.

Цэвэрлэх: Угаасны дараа бага хэмжээний туг ноос тасдан авч угаас нь мушгиж бариад үзүүрээс нь хялгасыг нь түүнэ, ингэж түүсний дараа

эргүүлээд үзүүр хэсгээс нь мушгиж бариад мөн л хялгасыг нь түүнэ. Хялгас түүхийн зэрэгцээ хог тоосыг нь унагааж цэвэрлэнэ.

Саманд оруулах: Хөөврийнхөө хялгасыг түүж, хогыг нь цэвэрлэнэ. Цэвэрлэсэн хөөврөө ноос сэмлэгч машинд оруулж самнана. Самнахдаа самнагч машины шүдний дунд хүртэл жигд самнаж өгнө. Самнахдаа цөөхөн эргүүлнэ.\1,2 удаа\ Их эргүүлвэл шаариглаад ээрэхэд төвөгтэй болно. Самнаад цувимал болгосны дараа ээрхэд бэлэн болсон байна. Хэрэв танд самнагч машин байхгүй тохиолдолд гар самаар самнаж цувимал болгож болно.

Ээрэх техниктэй хэрхэн ажиллах вэ?

Бэлтгэл ажил:

Тоног төхөөрөмжөө зөв байрлуулах

Машиныхаа бүтэц зохион байгуулалттай сайн танилцсан байх.

Ээрэх машины ард зөв сууж багшийн тайлбарыг анхааралтай сонсож даган дуурайх үйлдлээр ээрч эхэлнэ.

Ээрэхэд анхаарах зарчим:

- Зөв суух
- Цувимал шаардлага хангасан эсэхийг шалгах
- Жигд гишгэх / 1. 2. 3 амандаа тоолох/
- Нэгдүгээр эрчийг баруун гар тийш ээрэх
- Хоёр дахь эрчийг зүүн гар тийш ээрэх
- Цувилтыг тохируулж өгөх
- Эрчийг жигд өгөх
- Дамрандаа жигд ороох

Утасны ээрмэлийн олон төрлүүд байдаг.Үүнээс энгийн дан ээрэлтийн төрлийг ээрч сурах юм.

Энгийн ээрэлт:

- Дан ээрэлт
- Хоёр давхарлаж ээрэх
- Гурав давхарлаж ээрэх

Нарийн ээрэлт:

- Хэт нарийн ба бүдүүн ээрэх
- Ончроот ээрэлт
- Алаглан ээрэх
- Ноос хавчуулан ээрэх
- Хаягдал ашиглан ээрэх
- Бүдүүн эрчийг нарийн эрчтэй хослуулан ээрэх
- Олон давхарлаж ээрэх

Ээрэх цувималын орц найрлага: / Утасны найрлага /

- 100 % -ийн ноос / дан хонь, ямаа, тэмээ, сарлаг/
- 50 % -ийн хонь + ямаа
- 50 % -ийн хонь + тэмээ
- 50 % -ийн ямаа + тэмээ

Ээрэхэд хэрэглэгдэх тоног төхөөрөмж:

- Гар ээрүүл
- Механик ээрүүл
- Цахилгаан ээрүүл
- Үйлдвэрийн зориулалттай суурь ээрэх машинууд

Эдгээр тоног төхөөрөмжөөс дээрх 3 нь гэрийн нөхцөлд гар аргаар ээрхэд хамгийн тохиромжтой юм.

Утас ээрэх арга техник:

Сайтар боловсруулсан хонь, ямаа / ангор /, сарлаг, тэмээний ноолуураар утас ээрэх нь нэн тохиромжтой. Утас ээрэх үйл явц өөрийн гэсэн аргатай. Баруун гараараа эрчээ хойш нь гүйлгэхгүйн тулд чимхэж бариад зүүн гараараа ноолуураа задалж эрчинд оруулж өгнө. Дамараа эргүүлэхдээ хөл гишгүүрээ нэг, хоёр, гурав гэж аажуухан тоолж гишгэж өгнө.

Ээрэх ноолуураа 2 тэнцүү хувааж нэг нэгээр нь ээрнэ. Ээрэхдээ баруун гар тийш эргүүлж жигд эрчтэй нарийвтар ээрнэ.

Давхарлан ээрэх: Давхарлаж ээрэхдээ зүүн гар тийш эргүүлнэ. Мөн л баруун гараараа эрчийг хойш нь гүйлгэлгүйгээр чимхээд зүүн гараараа 2 дамартай утсаа суллаж эрчлэхэд бэлтгэж өгнө.

Угаах: Угаахдаа 40⁰-50⁰-н бүлээн усанд бага багаар зөөлөн булхуулж угаана. Эхэлж угаахдаа цэвэр усанд 15-12 минут дэвтээж байлгана. 2-дах усандаа бага зэргийн угаалгын нунтаг хийж 10 минут орчим булхуулж угаана. Дараагийн угаалт нь цэвэр усаар савангүй болтол зайлна. /Угаахдаа ноосон эдлэлд зориулсан шингэн хэрэглэвэл илүү тохиромжтой/ Үүгээр угаавал зөөлөн, хөвсгөр, өнгөлөг болно.

Сэгсрэх: Угаасан ноосон утсаа сэгсэрч усыг нь шавхана. Угаалгын машинд хийж тойруулан тавиад сэгсрэх. Мөн угаалгын машин байхгүй тохиолдолд торон тюленд ороож гараараа хүчтэй хэд хэдэн удаа дүүгүүрдэж ус гарахгүй болтол нь дүүгүүрдэнэ..

Ийнхүү сэгсэрсний дараагаар сүүдэр газар дагуулан тавьж хатаана.

Хатаах: Хатаахдаа сайтар дэлгэн, газраас хөндий тавибал илүү хурдан хатна. Наранд ил тавьж хатааж болохгүй.

Хавтгай амьтны дүрс хийх аргачлал

Бүтээгдэхүүний хэмжээ ба тавигдах шаардлага:

Хавтгай эсгийгээр хавтгай дүрс хийхдээ дотор нь чихэх ноосыг бага хийх хэрэгтэй.Тухайн хийх гэж буй дүрсний сүүл, оосор зэргийг сайтар бөхөлж өгөх шаардлагатай.Оосорыг хийхдээ 12 см томсон утсаар, эсвэл бэлэн гялгар утсаар хийж болно.Оосрыг дундуур нь нугалж 6 см болно.

Бүтээгдэхүүн хийхэд ашиглагдах материал тоног төхөөрөмж:

1. Угааж самнаж бэлтгэсэн ноос 10гр /бүтээгдэхүүний жин 10гр байх ба бүтээгдэхүүн хийх явцад эсгүүрийн хаягдал гархыг тооцож ноосыг илүү авах нь зүйтэй юм./
2. Хийх гэж буй амьтны дүрс буюу эсгүүр хийх үлгэр.
3. Ноосны өнгөтэй ижил өнгийн утас.
4. Дүрс дотор чихэгдэх цэвэр хуурай ноос, зүү.
5. Дүрсний ам, хамар, нүд оёх хар өнгийн ноосон утас.

Ажилбар:

1. Бүтээгдэхүүнд зориулж хавтгай эсгий бэлтгэх.
2. Эсгийн дээрээ үлгэрээ тавьж амьтны дүрсийг буулгах. / балын харандаагаар зурах шаардлагатай.Хэрэв бал ,үзгээр зурсан тохиолдолд дараа нь арилдаггүй муу талтай./
3. Дүрсний үлгэрийг 2 ширхэг эсгэж авна.
4. Эсгэсэн 2 үлгэрийг давхарлаж бариад ирмэгээр нь нийлүүлж оёно.

5. Дүрсийг тойруулж оёх явцдаа багахан хэсгийг оёлгүй үлдээж түүгээрээ дүрсэн дотроо ноосоо жигд нимгэн чихэж өгнө. Ингэж чихэсний дараа үлдсэн хэсгийг гүйцээж оёж дуусгана.
6. Хамар, ам, нүдийг нь оёж бүтээгдэхүүний гүйцэтгэлийг хийнэ.